



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

"УУЛ УУРХАЙН АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭЭС ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО, ОРОН НУТАГТ
ХИЙСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ТҮҮНИЙ ҮР АШИГ"-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: БНА-2024/31-1-ШТА-ГА

УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭЭС 2022-2023 ОНД
4,404.0 САЯ ТӨГРӨГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙСЭН НЬ ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД
ХУВЬ НЭМРЭЭ ӨГЧ БАЙНА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу
Цахим хуудас: www.open.audit.mn

Монгол улсын ерөнхий аудиторын
Орлогч Я.Самбууням
Утас: 99117703 цахим хуудас: sambuunyamyam@audit.gov.mn
Ахлах аудитор М.Алтантуяа
Утас: 70442424 цахим хуудас: Altantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Азбаяр
Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn
Аудитор Н.Батчимэг
Утас: 91113253 цахим хуудас: Batchimegn@audit.gov.mn

Баянхонгор хот 2024 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хуудас

Тайланг хянасан

Монгол Улсын Ерөнхий
аудиторын орлогч
Я.Самбууням
Аудитын менежер М.Алтантуяа

Тайланг бэлтгэсэн:

Ахлах аудитор Б.Азбаяр
Аудитор Н.Батчимэг

2024 оны 10 дугаар сарын 22-
ны өдөр

Уг тайланг УАГ-ын
цахим хуудаснаас үзнэ үү:
www.open.audit.mn

Аудитын тайлантай холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70442424 дугаарын утас,
70442584 дугаарын факсаар
харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь Төрийн
аудитын газар, Нутгийн
удирдлагын ордон,
Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум 64090,
Баянхонгор аймаг
Монгол Улс

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
Үндсэн мэдээлэл	5
БҮЛЭГ А. ОРОН НУТАГТ УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХУУЛЬ, ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО ЧИГЛЭЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДАЖ БАЙНА УУ?	6
Дүгнэлт А. ЭКОЛОГИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫГ ХАНГАСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖТЭЙ УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙГ ДЭМЖИЖ, ЭВДЭРСЭН ГАЗРЫГ НӨХӨН СЭРГЭЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.	6
А.1. Аймгийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан уул уурхайн талаарх зорилт, арга хэмжээ нь улсын хэмжээний бодлого зорилттой уялдаж, хэрэгжилт хангагдаж байна уу?	6
А.1. Баянхонгор аймгийн 2021-2025 онд хэрэгжүүлэх дунд хугацааны үндсэн чиглэлийг "Алсын хараа 2050"-д уялдуулсан байна. Цаашид нэмүү өртөг шингээх, боловсруулах үйлдвэр байгуулах зорилтыг тусгах боломжтой байна.	6
А.2. Уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчинд нийцүүлэн үйл ажиллагаа явуулж байна уу?	10
А.2. Уул уурхайг ашиглах ТЭЗҮ-д туссан дэд бүтцийн болон хөрөнгө оруулалтын арга хэмжээг шаардлагад нийцүүлэн гүйцэтгүүлсний дараа уурхайг ашиглаж эхлэхэд төрийн холбогдох байгууллагууд анхаарах шаардлагатай байна.	10
А.3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хуулийн хүрээнд хэрэгжиж байна уу?	14
А.3. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөгөөт болон дүйцүүлэх байдлаар хийж байгаа боловч эвдэрсэн газрын хэмжээ буурахгүй байна.	14
БҮЛЭГ Б. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ОРЛОГЫГ ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨЖ, ТӨСӨВТ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ҮҮ?	17
Дүгнэлт Б. Уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдээс орох орлогыг төлөвлөхдөө хийсэн тооцоололд үндэслээгүй, газрын төлбөрийн төрийн байгууллагын уялдаа холбооноос шалтгаалан зөрүүтэй ногдуулсан байна.	17
Б.1. Уул уурхайн салбарын төсвийн орлогыг нэр төрөл, тоо хэмжээгээр төлөвлөж, холбогдох хууль тогтоомжийн дагуу ногдуулж байна уу?	17
Б.1. Уул уурхайн салбарын ААН-үүдийн татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.	17
Б.2. Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт иж бүрэн байна уу?	24
Б.2. Уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.	24
БҮЛЭГ В. УУЛ УУРХАЙН САЛБАРААС ОРОН НУТАГТ ХИЙХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨЖ, ҮР АШИГТАЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮҮ?	27
Дүгнэлт В. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУССАН ЗАРИМ АЖЛЫГ УУЛ УУРХАЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИЙДВЭРЛЭСЭН НЬ ҮР АШГАА ӨГЧ БАЙНА.	27
В.1. Уул уурхайн салбарын хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтууд төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?	27
В.1. Баянхонгор аймгийн Хөгжлийн төлөвлөгөөнд 2022 онд тусгагдсан хөрөнгө оруулалтыг уул уурхайн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр болж байна.	27
В.2. Уул уурхайн салбарын хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт ашиглалтад бүрэн орж бүртгэл тайланд тусгасан уу?	30
В.2. Уул уурхайн салбарын хөрөнгөөр хийгдсэн 307.4 сая төгрөгийн 3 хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.	30
ДҮГНЭЛТ:	33
ЗӨВЛӨМЖ:	34
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:	35

Товчилсон үгийн тайлбар

АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
ААН	Аж ахуйн нэгж
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ГМУБЭУСБГХБОСБГАМХАХТ	Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай
ГУМС	Газрын удирдлагын мэдээллийн систем
ГХБХБГ	Газрын харилцаа, борилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗТБХБЯ	Зам тээвэр, барилга хот байгуулалтын яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
ЭЗТХ	Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс

Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлсэн орлого, орон нутагт хийсэн хөрөнгө оруулалт түүний үр ашиг

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Томоохон төслийн орон нутагт төвлөрүүлэх орлогын тооцоо	8
Хүснэгт 2	Аймгийн Засаг даргатай 2022, 2023 онд гэрээ байгуулсан уул, уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн гэрээний үүргийн биелэлтийн судалгаа	12
Хүснэгт 3	Хог хаягдалд хяналт хийсэн шалгах хуудас	14
Хүснэгт 4	Газрын төлбөрийн 2022, 2023 оны төсвийн төслийн тооцоолол	17
Хүснэгт 5	Усны төлбөрийн 2022, 2023 оны төсвийн төслийн тооцоолол	17
Хүснэгт 6	Уул уурхайн ААН-үүдийн татварын орлогын төсвийн төсөл	18
Хүснэгт 7	Баянхонгор аймгийн тусгай зөвшөөрөл сумдаар	18
Хүснэгт 8	Талбайн хэмжээ зөрүүтэй ААН-ийн жагсаалт	20
Хүснэгт 9	Хог хаягдлын хураамжийн ногдол, гүйцэтгэл	23
Хүснэгт 10	Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаанаас аймгийн Татварын хэлтэст хүргүүлсэн усны төлбөрийн ногдуулалт	24
Хүснэгт 11	Татварын орлогын 2022, 2023 оны ногдол, гүйцэтгэл	25
Хүснэгт 12	Газрын төлбөрийн орлого дутуу төлсөн ААН-ийн жагсаалт	25
Хүснэгт 13	Хог хаягдлын хураамжийн орлого дутуу төлсөн ААН-ийн жагсаалт	26
Хүснэгт 14	Усны төлбөр тооцоо	26
Хүснэгт 15	Нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй хөрөнгө оруулалтын жагсаалт	31

Зургийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	"Одод гоулд" ХХК-ийн MV-007468 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай	20
Зураг 2	"Эл Ти Ди" ХХК-ийн MV-021059 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай	21
Зураг 3	"Сэкер ресорсус монголиа" ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай	22

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/100 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/162 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, газрын дарга тэргүүлэх аудиторов 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай тушаал”-ын дагуу аудитыг гүйцэтгэв.

Аудитын зорилт

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэр дээр ашиглалтын болон хайгуулын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлсэн орлого, орон нутагт хийсэн хөрөнгө оруулалт түүний үр ашиг сэдэвт аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Орон нутагт уул уурхайн салбарын хууль, төрөөс баримтлах бодлого чиглэл, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны хэрэгжилт хангагдаж байгаа эсэх;
- Уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдийн үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр, рашаан, ус ашигласны төлбөр, газрын төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг оновчтой төлөвлөж, төсөвт бүрэн төвлөрүүлсэн эсэх;
- Уул уурхайн салбараас орон нутагт хийх хөрөнгө оруулалтыг бодитой төлөвлөж, үр ашигтай хэрэгжүүлсэн эсэх;

Аудитын хамарсан хүрээ

Баянхонгор аймгийн нутаг дэвсгэр дээр ашиглалтын болон хайгуулын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс Баянхонгор аймагт 2022, 2023 онд орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн орлого, ногдуулалт, гүйцэтгэл, хийж хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээ, олгосон санхүүжилт, хандив, бусад хөрөнгө оруулалт, нийгмийн хариуцлагын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар Төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн харьяа байгууллагууд болон сумдын Засаг дарга, аймгийн ЗДТГ, Баянхонгор аймгийн ГХБХБГ, Татварын газар, Бөөнцагаан-Орон нуурын сав газрын захиргаа, Орон нутгийн өмчийн газар зэрэг холбогдох бусад байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгжийг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, татварын орлогын ногдуулалт, биелэлт, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг хамруулан аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын хязгаарлалт

Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс улсын төсөвт төвлөрүүлдэг татвар (ААНОАТ, НӨАТ, АМНАТ, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, ус бохирдуулсны төлбөр) болон түгээмэл тархацтай ашигт ашигт малтмалын орлого, 2022, 2023 онд бичил уурхайн үйл ажиллагаа зогссон тул хамруулаагүй болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 400, 3000-3001, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020, Гүйцэтгэлийн аудитын зарчим, 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106

Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа

дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авч, харьцуулалт хийн, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитыг МУЕА-ын орлогч Я.Самбууням хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер М.Алтантуяа хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Н.Батчимэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв. Аудитын талбарын үе шатны ажлыг 2024 оны 08 дугаар сарын 28-аас эхлэн гүйцэтгэсэн ба аудиторуд талбарын ажлын явцад тайлангийн төслийг бичиж, аудитын тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар 10 дугаар сарын 09-ний өдөр хэлэлцүүлж, тайланг баталгаажуулан ҮАГ, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Хүндрэл
бэрхшээл

Аймгийн төрийн байгууллагуудад уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн уурхай ашиглах ТЭЗҮ байхгүй, нэгдсэн судалгаа, холбогдох баримт материал байхгүй байсан нь аудитын хугацаанд хүндрэл бэрхшээл учруулж байлаа.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Баянхонгор аймагт ашиглалтын 97 тусгай зөвшөөрөл, хайгуулын 38 тусгай зөвшөөрөл эзэмшигч бүртгэлтэй ба Баянхонгор аймгийн нийт газар нутгийн 3.2 хувь буюу 366,919.25 га талбайг эзэлж байна.

Баянхонгор аймгийн Засаг дарга уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх" гэрээг 2022-2023 онд нийт 12 аж ахуй нэгжтэй 12,780.0 сая төгрөгөөр байгуулж 2022 онд 3,455.0 сая, 2023 онд 3,065.0 сая төгрөгийн орлого оруулахаар тусгажээ.

Орон нутгийн төсөвт уул уурхайн тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдээс газрын төлбөрөөс 2022 онд 296.7 сая, 2023 онд 464.0 сая, ус, рашаан ашигласны төлбөрөөс 2022 онд 553.0 сая, 2023 онд 395.3 сая төгрөг, хог хаягдлын хураамжаас 2022 онд 17.3 сая, 2023 онд 11.8 сая төгрөг төвлөрсөн байна.

Баянхонгор аймгийн ОНХС-ийн дансанд 2023 онд уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс 2,605.0 сая төгрөгийн хандивын орлого төвлөрчээ.

Эвдэрсэн газрын 2021 оны тооллогоор аймгийн хэмжээнд 120 нэгж талбарт 586.74 га газарт эвдрэлд орсон байсан бол 2023 оны тооллогоор 224 нэгж талбарт 729.4 га эвдрэлд орсон байна. Үүнээс 2021-2022 онд 174.4 га 2023 онд 43.98 га нийт 218.38 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийсэн байна.

Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газраас 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хооронд арга зүйн зөвлөгөө авсан.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ А. *ОРОН НУТАГТ УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ХУУЛЬ, ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГО ЧИГЛЭЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАНГАГДАЖ БАЙНА УУ?*

ДҮГНЭЛТ А. ЭКОЛОГИЙН ТЭНЦВЭРТ БАЙДЛЫГ ХАНГАСАН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖТЭЙ УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙГ ДЭМЖИЖ, ЭВДЭРСЭН ГАЗРЫГ НӨХӨН СЭРГЭЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

А.1. *Аймгийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан уул уурхайн талаарх зорилт, арга хэмжээ нь улсын хэмжээний бодлого зорилттой уялдаж, хэрэгжилт хангагдаж байна уу?*

А.1. Баянхонгор аймгийн 2021-2025 онд хэрэгжүүлэх дунд хугацааны үндсэн чиглэлийг “Алсын хараа 2050”-д уялдуулсан байна. Цаашид нэмүү өртөг шингээх, боловсруулах үйлдвэр байгуулах зорилтыг тусгах боломжтой байна.

А.1.1. Урт хугацааны хөгжлийн бодлогод уул уурхайн талаар тусгасан зорилт, арга хэмжээний хэрэгжилт хангагдаж байна уу?

Орон нутгийн түвшинд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг үндэслэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Монгол Улсын Их Хурлаас 2020 онд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 4.2¹ дугаар зорилтын 2-т “Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдсэн байна” гэж заасан байна.

Хариуцлагатай уул уурхайг эдийн засгийн тэргүүлэх салбар болгон аймгийн 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, дунд хугацааны бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгаж биелэлтийг аймгийн ИТХ-д жил бүр тайлагнан ажилласан байна.

Харин “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд уул уурхайн түүхий эдийг боловсруулан нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн гаргах талаар тусгасан нь орон нутгийн бодлогын түвшинд нэмүү өртөг шингээх, боловсруулах үйлдвэр байгуулах зорилтыг цаашид төлөвлөх боломжтой байна.

Иймд уул уурхайг түшиглэсэн нэмүү өртөг шингээх, боловсруулах үйлдвэр байгуулах зэрэг бодлогыг урт дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгах зөвлөмжийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд толилуулав.

А.1.2. Аймгийн урт, дунд хугацааны бодлогын баримт бичигт уул уурхайн салбарын бодлогыг тусгаж, хэрэгжүүлж байна үү?

¹ Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно.

Баянхонгор аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд уул, уурхайн салбарт хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх зорилт тавьж хууль сурталчлах, соён гэгээрүүлэх сургалтыг зохион байгуулж ажилласан байна.

Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2020 оны 2/6 тоот тогтоолоор Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлахдаа Эдийн засгийн тэргүүлэх чиглэлүүдийн 4.2.1-т "Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, бичил уурхай эрхлэгчдийг дэмжиж ажиллана" гэж тодорхойлсон байна.


Аймгийн Засаг дарга Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар болон бусад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран "Хариуцлагатай уул уурхай" зөвлөгөөнийг 2022, 2023 онуудад тусгай зөвшөөрөл эзэмшигчид, бичил уурхай эрхлэгч иргэдийн төлөөлөл, сумдын Засаг даргын тамгын газрыг оролцуулан давхардсан тоогоор 500 гаруй иргэдийг хамруулан 2-3 удаа зохион байгуулсан байна.

Зөвлөгөөнөөр салбарын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, орон нутгийн хамтын ажиллагаа тэдгээрийн хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч, санал солилцсон.

Хэлэлцүүлгийн үр дүнд эрдэс баялаг, байгаль орчны салбарын хууль тогтоомжийг сурталчилж, уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс 2022, 2023 онд хийсэн хөрөнгө оруулалт, хандив, тусламжийн зарцуулалтын тайланг олон нийтэд танилцуулсан. Мөн цаашид хариуцлагатай уул, уурхайн аж ахуйн нэгжүүд хамтын ажиллагааг сайжруулах, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн төлөөлөл, мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэй хамтран тулгамдсан асуудлыг шийдвэрлэсэн.

Монгол банкны мэдээгээр 2018 онд 85 гулдмайгаар 79.6 кг алт худалдан авч байсан ба сүүлийн 4 жил дараалсан 1.1 тонноос дээш хэмжээтэй худалдан авалтыг хийж байгаагаас үзэхэд зөвлөгөөний үр дүн зарим хэлбэрээр гарч байна гэж үзэхээр байна.

Дүрслэл № 1. Баянхонгор аймаг дахь Монгол банкны салбарт тушаасан алтны хэмжээ



Эх сурвалж: Баянхонгор аймаг дахь Монгол банкны тайлангаас

А.1.3. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөр болон жилийн хөгжлийн төлөвлөгөөнд уул уурхайн салбарын бодлогыг тусгаж, хэрэгжүүлж байна үү?

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөрт уул уурхайн салбарын бодлогыг тусгаж биелэлтийг жил бүр хөгжлийн төлөвлөгөөний биелэлтээр тайлагнасан байна.

Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2020 оны 2/7 дугаар тогтоолоор "Аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг батлахдаа уул уурхайн салбарыг "Хариуцлагатай уул уурхай-Эдийн засгийн үндэс" хэмээн тодорхойлж орон нутагт уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн үйл ажиллагааг дэмжин эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх дараах 5 зорилтыг тусгажээ.

1. Орон нутагт уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдтэй байгуулах гэрээнд төр, иргэдийн оролцоог хангаж ажиллах.

"Байгаль орчныг хамгаалах, уул уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх" 8 гэрээг байгуулж биелэлтийг дунджаар 95 хувьтай үнэлсэн.

2. "Хариуцлагатай уул уурхай-Эдийн засгийн үндэс" сургалтыг уул уурхай бүхий сумдын иргэдэд зохион байгуулах

Хариуцлагатай уул уурхай сургалтыг уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа 7 сумдад 6 сэдвээр зохион байгуулж 200 гаруй иргэдийг хамруулсан.

3. "Баялагийн сан" байгуулж, олон нийтийн хяналтын дор байгаль хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн шинжтэй төсөл хөтөлбөрийг иргэдийн оролцоотой хийж хэрэгжүүлнэ.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 8/07 дугаар тогтоолоор "Баялагийн сан"-г байгуулсан боловч Төсвийн тухай хуультай нийцээгүйгээс шалтгаалан Хууль зүйн яам уг сангийн журмыг бүртгээгүй байна.

4. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай эрхлэгчдийг дэмжиж ажиллана.

Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор баталсан "Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох" журмын дагуу Бууцагаан сумд 1, Бөмбөгөр сумд 3, Галуут сумд 1 бичил уурхайг ажиллуулсан. Шүүхээс хууль бусаар ашигт малтмал эрэн хайсан 164 хэргийг бүртгэж, 139 хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж 19 зөрчлийн шинжгүй гэж үзэн татгалзаж, харьяаллын дагуу 6 зөрчлийн хэргийг шилжүүлсэн.

5. Эвдэрсэн газрын тооллого, судалгаан дээр үндэслэн төлөвлөгөө гаргуулж батлуулах

Эвдэрсэн газрын судалгаагаар 2021 оны аймгийн хэмжээнд 120 нэгж талбарт 586.74 га газарт эвдрэлд орсон байсан бол аймгийн Засаг даргын 2023 оны А/317 дугаар захирамжаар томилсон ажлын хэсгийн тооллогоор 224 нэгж талбарт 729,4 га эвдрэлд орсон байна. Үүнээс 2021-2022 онд 174.4 га 2023 онд 43.98 га нийт 218.38 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийсэн гэж дүгнэсэн байна.

Аудитаар аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр болон жилийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 2023 оны жилийн эцсийн байдлаар зарим зорилт нь хууль тогтоомжийн хязгаарлалтаас болж бүрэн хэрэгжээгүй, өмнөх суурь үзүүлэлтээс

ахиц гараагүй байхад хангалттай гэж үнэлсэн нь бодит бус байна. Тухайлбал: Аймгийн хэмжээнд 2021 онд 586.7 га , 2023 онд 729.4 га эвдэрсэн газар байна гэж тооллогоор гарсан байхад бүрэн хангалттай гэж дүгнэсэн.

Энэ талаар аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэргэжилтнээс тодруулахад “2021 онд сумдаас судалгаа авч эвдэрсэн газрын хэмжээг тодорхойлсон, 2023 онд ажлын хэсэг гарч нарийн хэмжсэн тул нэмэгдсэн” гэсэн тайлбар өгөв.

Иймд Засаг даргын 4 жилийн үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргахдаа бодитой тоон үзүүлэлтийг гарган үнэн зөв мэдээллээр хангаж байх зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын даргад хүргүүлэв.

А.1.4. Уул уурхайн аж ахуйн нэгжүүд орон нутгийн цаашдын хөгжлийн хандлага, төсвийн орлого бүрдүүлэлт, бие даасан байдлыг хангах боломж байна уу?

Уул уурхайн томоохон төслүүдийн ТЭЗҮ-ээс эдийн засгийн тооцоолол хийж үзэхэд Баянхонгор аймгийн орон нутгийн орлого өсч улсын төсвийн ачааллыг бууруулах боломжтой байна.

Орон нутаг улс орны эдийн засгийн чиг хандлага баримталж буй бодлогыг дагаж уул уурхайн салбарыг тэргүүлэх чиглэлээр тодорхойлсон байна.

Уул уурхайн компаниудын ТЭЗҮ-ийг орон нутгийн түвшинд нэгтгэсэн судалгаа шинжилгээ аймгийн холбогдох төрийн байгууллагын мэдээллийн санд байхгүй байна.

Эдийн засгийн үр өгөөжийн хувьд томоохон дараах төслүүдийг хэрэгжүүлэхэд орон нутагт цаашид орлого бүрдүүлэлт нэмэгдэх боломжтой байна.

Хүснэгт № 1. Томоохон төслийн орон нутагт төвлөрүүлэх орлогын тооцоо (сая төгрөг)

№	Татварын төрөл	Сэкер ресурсус	Жилд дунджаар орох орлого	Эрдэнэ Монгол	Жилд дунджаар орох орлого	Нийт жилийн орлого	Үүнээс орон нутагт төвлөрөх
1	АМНАТ	1,812,185.1	120,812.3	56,510.0	11,302.0	132,114.3	
2	Тусгай зөвшөөрлийн төлбөр	696.9	46.5	490.0	98.0	144.5	
3	Газар ашигласны төлбөр	2,850.8	190.1	70.0	14.0	204.1	204.1
4	Ус ашигласны төлбөр	39,221.1	2,614.7	1,840.0	368.0	2,982.7	2,982.7
5	ААНОАТ	1,791,413.8	119,427.6	151,840.0	30,368.0	149,795.6	59,918.2
6	НДШ	112,541.6	7,502.8	4,410.0	882.0	8,384.8	
7	ХХОАТ	31,739.5	2,116.0	1,940.0	388.0	2,504.0	2,504.0
8	Үл хөдлөх хөрөнгийн татвар	876.3	58.4		-	58.4	58.4
9	Агаарын бохирдлын төлбөр	103,423.8	6,894.9		-	6,894.9	6,894.9
10	АТӨЯХАТ	443.7	29.6	20.0	4.0	33.6	33.6
11	Гаалийн татвар	142,158.6	9,477.2		-	9,477.2	
12	НӨАТ	15,626.0	1,041.7		-	1,041.7	
13	ОНХС			1,000.0	200.0	200.0	200.0
	Нийт	4,053,177.2	270,211.8	218,120.0	43,624.0	313,835.8	72,795.9

Эх сурвалж: Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ТЭЗҮ

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Баянхөндий төслийн ТЭЗҮ-г 2019 онд тодотгосон ба Монгол банкны алтны дундаж ханш 2019 оны 9 дүгээр сарын байдлаар 127.0 мянган

т/гр байсан бол 2024 оны 9 дүгээр сарын байдлаар 286.0 мянган т/гр болж ханш 2.25 дахин өссөн байна.

Дээрх тооцооноос үзэхэд татварын орлогыг дүйцүүлэн нэмж үзэхэд 449,709.8 сая төгрөгийн татвар төлбөр хураамж улс, орон нутгийн төсөвт төвлөрөх тооцоолол гарч байгаа ба үүнээс 82,779.4 сая төгрөг орон нутгийн төсөвт төвлөрөхөөр байна.

Аймгийн ТЭЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд нийт зарлагын дүнг 77,916.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 69,931.0 сая төгрөгийг зарцуулсантай харьцуулахад дээрх төслийн хугацаанд орон нутгийн орлого эрс өсөж улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг бууруулахаар байна.

Мөн Баянхөндий төслийн ТЭЗҮ-д жилд дунджаар 2063.0 тн буюу 66334 унц алтыг тушаахаар тооцсон байсан бол 2024 оны 10 дугаар сарын эхний хагасын Bloomberg-ийн мэдээллээр 2026 оноос 2643.0 тн буюу 85000 унц алтыг олборлохоор нөөц нэмэгдэж байгаа талаар мэдээлж байна. <https://www.mongolbank.mn/mn/gold-and-silver-price>

Баянхонгор аймгийн нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 2023 оны байдлаар 7.9 сая төгрөг байгаа бол төсөл хэрэгжих хугацаанд ТЭЗҮ-д заасан нийт коксжих болон эрчим хүчний зориулалтаар экспортлох нүүрсний үнийг “Уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны систем” дэх “Таван толгой” ХК-ийн доод үнэ ханшаар тооцоход нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 25.0 сая төгрөгөөр нэмэгдэж 30.0-33.0 сая төгрөгт хүрэх урьдчилсан таамаглал байна. /тооцооллыг хавсралтаар харуулав./

Баянхонгор аймагт хөдөлмөрийн насны бүртгэлтэй ажилгүй иргэд 2023 оны жилийн эцсийн байдлаар 3151 хүн байгаа бол “Сэкер ресорсус Монголиа” ХХК-ийн нүүрсний уурхайд үндсэн ажилтнаар 1116 хүн, цахилгаан станцад 205 ажлын байр шинээр нэмэгдэхээр ТЭЗҮ-д тусгасан бол “Эрдэнэ Монгол” ХХК 359 ажлын байрны 70-80 хувийг орон нутгаас авахаар төлөвлөсөн байгаагаас үзэхэд ажилгүйдлийн түвшин эрс буурах төлөвтэй байна.

Дээрх 2 төсөл хэрэгжсэнээр жижиг дунд үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ, ложистик зэрэг бусад бизнесийн салбар өргөжиж, улмаар ажлын байр нэмэгдэх боломж үүсэж байна.

А.2. Уул уурхайн салбарын хууль эрх зүйн орчинд нийцүүлэн үйл ажиллагаа явуулж байна уу?

А.2. Уул уурхай ашиглах ТЭЗҮ-д туссан дэд бүтцийн болон хөрөнгө оруулалтын арга хэмжээг шаардлагад нийцүүлэн гүйцэтгүүлсний дараа уурхайг ашиглаж эхлэхэд төрийн холбогдох байгууллагууд анхаарах шаардлагатай байна.

А.2.1. Уул уурхайн аж ахуйн нэгжүүд орд ашиглах ТЭЗҮ-д байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг тооцож, дэд бүтэц, байгалийн бусад нөөцийг төсөл хэрэгжихүйцээр тусгасан уу?

Уул уурхайн томоохон төслийн ашиглалтыг эхлүүлэхээс өмнө Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор орд ашиглах ТЭЗҮ-д туссан дэд бүтэц болон хөрөнгө оруулалтын ажлуудыг гүйцэтгүүлсэн байх шаардлагатай байна.

Баянхонгор аймгийн Шинэжинст сумд ашиглах “Сэкер ресурс Монголиа” ХХК-ийн “Хотгор”-ын чулуун нүүрсний уурхайн усан хангамжийн эх үүсвэрийн судалгааг анх 2008 оноос хийсэн бөгөөд талбай орчмын 100 км-ийн радиуст хэд хэдэн усан хангамжийн эх үүсвэрийн нөөц бололцоо бүхий газруудыг тогтоосон байна. Тус судалгаагаар шүүрлийн усыг уурхайн баруун хойд хэсэгт нийт 8 шүүрүүлэх цооног байгуулж ашиглахаар төлөвлөсөн байна.

Цахилгааны эх үүсвэрт 18 мега байтын цахилгааны станц байгуулж, “Сэкер ресурс Монголиа” ХХК нь Нарийн сухайтаас Шивээ хүрэн боомт чиглэлийн 43.2 км хатуу хучилттай замаар бүтээгдэхүүнээ тээвэрлэж борлуулахаар тооцон “Хотгор”-ын нүүрсний уурхайгаас Нарийн сухайт хүртэл 288.5 км замыг барихаар ЗТБХБЯ-аас (хуучин нэрээр) 2012.01.13-нд зөвшөөрөл авсан байна /ТЭЗҮ-ээс/.

“Эрдэнэ Монгол” ХХК-ийн Баянхөндий төсөл 2017 онд Алтан нар болон Баянхөндий алтны үндсэн ордуудыг түшиглэн байгуулагдах уулын баяжуулах үйлдвэрүүдийн технологийн ус хангамжийн эх үүсвэрт ашиглагдах газрын доорх усны нөөцийн хэтийн төлөв бүхий талбайнуудыг илрүүлэн тогтоох гидрогеологийн эрлийн судалгааны ажлыг явуулсан. Энэхүү эрэл, хайгуулын гидрогеологийн судалгааны үр дүнд баяжуулах үйлдвэрийн ус хангамжийн эх үүсвэрийг Баянхөндий ордоос 1.5-2.8 км зайд, ахуйн хэрэглээний усны эх үүсвэрийг кемпийн байрлалаас 0.3-1.6 км зайд тогтоож газрын доорх усны ашиглалтын нөөцийг үйлдвэрлэлийн С зэргээр үнэлсэн.

Цахилгааны хувьд Эрдэнэт-Булганы 110кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам нь Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын нутаг дахь Баян тээгийн уурхай дээр ирдэг. Тус уурхай дахь 110/35кВ-ын Баян тээг дэд станцаас Баянхонгор аймгийн Баянлиг, Шинэжинст сумдыг дайруулан татсан 35 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугамаар цахилгаан эрчим хүч авах тооцоотой байсан боловч уурхайн ойролцоо цахилгаан станц барих ажлыг 2023 оноос эхлүүлсэн байна.

Харин орон нутагт хатуу хучилттай замын ажил хийгдэхээр төлөвлөж байгаа гэх боловч одоогоор замын ТЭЗҮ хийгээгүй, нотлох баримт байхгүй байна.

Иймд байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулахаар ТЭЗҮ-д хийгдэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын судалгааг гарган дэд бүтэц, хөрөнгө оруулалтын ажлыг хийсний дараа уурхайг ашиглах гэрээ хэлэлцээр, холбогдох зөвшөөрлийг орон нутгаас олгох асуудлыг анхаарч ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөв.

Аудит хийх үеэр Бөмбөгөр сумын нутаг дэвсгэрт алт олборлох үйл ажиллагаа явуулж буй “Одод гоулд” ХХК нь олборлолт хийхдээ голын урсгалын хамгаалалтын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа нь ГМУБЭУСБГХБОСБГАМХАХТ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.12 дахь заалтыг зөрчиж байж болзошгүй тул агаараас бичлэг хийн баримтжуулав.

Улсын байцаагчийн хяналтаар илэрсэн зөрчлийг хэрхэн арилгасан талаар биелэлтийн тайлан байхгүй байна.

А.2.2. Төрийн байгууллагууд хууль журамд заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж байна уу?

Орон нутаг дахь төрийн байгууллагууд нь байгаль орчныг хамгаалах хяналтын чиг үүргээ дутуу хэрэгжүүлэн ажилласан байна.

Уул уурхайн салбарын бодлого, түүний хэрэгжилтийг зохион байгуулах, олборлолт байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд төрийн байгууллагуудын чиг үүргийн хуваарилалтыг авч үзэв.

Аймгийн Засаг дарга нь орон нутгийн түвшинд байгаль орчныг хамгаалах бодлого боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах үүргийг хүлээж, аймгийн БОАЖГ нь байгаль орчныг хамгаалах чиглэлийн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Харин Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа нь өөрийн хариуцсан сав газрын хэмжээнд усны зүй зохистой ашиглах, түүнд хяналт тавих чиг үүргийг хүлээж байна.

Ажил үүрэг хуваарилалтын хувьд Байгаль орчны хяналтын улсын байцаагч нь байгаль хамгаалах нөхөн сэргээх чиглэлээр хяналт хийдэг бол геологи уул уурхайн хяналтын улсын байцаагч нь олборлох үйлдвэр чиглэлээр хяналт шалгалтыг хийж байна.

Улсын байцаагчийн болон мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтууд агуулгын хувьд ижил төстэй байгааг судалж чиг үүргийн хуваарилалтыг нарийн тусгах шаардлагатай байгаа тул "Төрийн байгууллагын хүний нөөцийн бодлого, тогтолцооны үр нөлөө"-нд хийж буй тогтолцооны аудитаар нарийвчлан шалгуулахаар аудитын багт мэдээллийг хүргүүлэв.

Дээрх төрийн байгууллагууд нь уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд өөр өөрийн чиглэлээр жилд 2-3 удаа хяналт шалгалт, уулзалт сургалтыг зохион байгуулж, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлсэн байна.

Байгаль орчны асуудал хариуцсан гол мэргэжлийн байгууллагын хувьд БОАЖГ-дараах чиг үүргийг хэрэгжүүлсэн ажилласан байна.

- Уул уурхайн хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг бүртгэсэн
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт хийсэн.
- Уул уурхайн ашиглалтын болон хайгуулын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлтийг хүлээн авсан
- Байгаль орчны багц хуулийг хэрэгжүүлж, байгаль орчны эсрэг гэмт хэрэг зөрчлийг таслан зогсоож, хяналт шалгалт хийсэн

А.2.3. Аймгийн засаг даргын уул уурхайн аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг бүрэн хангуулж хяналт тавьж ажилласан уу?

Аймгийн ТЕЗ-ийн 2022-2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар уул уурхай компаниуд аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээгээ дүгнүүлээгүй зөрчлийг илрүүлж, зөвлөмж хүргүүлсэн боловч бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Аймгийн Засаг дарга 2022 онд 11, 2023 онд 8 уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй "Байгаль орчныг хамгаалах, уул уурхай ашиглах үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ" байгуулж гэрээний үүргийн хэрэгжилтийг дүгнэж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд хүргүүлсэн бол 2022 онд 6 ААН, 2023 онд 3 ААН тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гэрээгээ дүгнүүлээгүй байна.

Хүснэгт № 2. Аймгийн Засаг даргатай 2022, 2023 онд гэрээ байгуулсан уул, уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн гэрээний үүргийн биелэлтийн судалгаа

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Гэрээ байгуулсан огноо	Гэрээ дүгнэсэн огноо	Гэрээний хэрэгжилтийн хувь
1	Галуут	"Монголболгаргео" ХХК	2022.04.25	2023.02.06	96
2	Бөмбөгөр	"Ай Эн Ди" ХХК	2022.05.09	2023.01.30	93.6
3	Баян-Овоо	"Стар холдинг" ХХК	2022.06.15	2023.01.27	92.5
4	Галуут	"Топ ган дриллинг" ХХК	2022.08.30	2023.06.26	90
5	Бөмбөгөр	"Ти энд ти юникс" ХХК	2022.04.26	-	-
6	Бөмбөгөр	"Хишигт хөндий" ХХК	2022.04.26	-	-
7	Бөмбөгөр	"Женри" ХХК	2022.05.31	-	-
8	Гурванбулаг	"Жи эс би ресурс" ХХК	2022.06.20	-	-
9	Галуут	"Вестерн ресурс" ХХК	2022.07.25	-	-
10	Галуут	"Шижир аранжин" ХХК	2022.09.02	-	-
11	Шинэжинст, Баян-Өндөр	"Эрдэнэ Монгол" ХХК	2022.06.21	2024.02.14	100.0
1	Бөмбөгөр	"Ай Эн Ди" ХХК	2023.05.10	2024.02.02	95.0
2	Галуут	"Монголболгаргео" ХХК	2023.06.05	2024.03.21	98.5
3	Галуут	"Топ ган дриллинг" ХХК	2023.05.10	2024.05.14	94.28
4	Бөмбөгөр	"Вояжер минерал ресурс" ХХК	2023.08.28	2024.08.28	95.0
5	Галуут	"Шижир аранжин" ХХК	2023.06.15	-	-
6	Галуут	"Өнө буянт ундрах" ХХК	2023.08.30	-	-
7	Бөмбөгөр	"Мэлтэс оргих" ХХК	2023.09.01	-	-
8	Баян-Овоо	"Наранмандал Энтерпрайзес" ХХК	2021.05.31	-	-

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн дагуу аймгийн Засаг даргаас холбогдох ААН-үүдэд 2024.09.30-ны дотор гэрээгээ дүгнүүлэх албан бичгийг хүргүүлсэн боловч 2024.10.04-ний байдлаар гэрээгээ дүгнүүлээгүй байна.

Иймд дээрх гэрээ дүгнүүлээгүй аж ахуйн нэгжийг холбогдох хууль журмын дагуу дараагийн арга хэмжээ авч ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

А.2.4. Аймгийн орон нутгийн хэмжээнд уул уурхайн чиглэлээр гаргасан шийдвэрийг олон нийтэд ил тод нээлттэй мэдээллээр хангаж ажилласан уу?

Уул уурхай компаниудын аймгийн Засаг даргатай байгуулсан 2022, 2023 оны гэрээний биелэлтийг олон нийтэд ил тод мэдээлээгүй байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцлийн аудитын сорил гүйцэтгэсэн бөгөөд уул уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа "Мэлтэс Оргих" ХХК, "Монгол болгар гео" ХХК, аймгийн Засаг дарга нарын хооронд 2023 онд байгуулсан "Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх тухай гэрээ"-г шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй зөрчилд зөвлөмж хүргүүлж, биелэлтийг хангуулан ажилласан байна.

Баянхонгор аймгийн ТЕЗ нь Bayankhongor.gov.mn цахим хуудсыг 2023 оноос бүрэн ажиллуулж эхэлсэн бөгөөд уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээг тус сайтад байршуулж ажилласан байна.

Харин гэрээний биелэлтийг олон нийтэд мэдээлээгүй, сумдын ИТХ-д хүргүүлж мэдээлэх ажил хийгдээгүй байгаа тул мэдээллийг олон нийтэд түгээх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлэв.

А.3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ хуулийн хүрээнд хэрэгжиж байна уу?

А.3. Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээг төлөвлөгөөт болон дүйцүүлэх байдлаар хийж байгаа боловч эвдэрсэн газрын хэмжээ буурахгүй байна.

А.3.1. Аж ахуйн нэгжүүд байгаль орчны болон хорт бодис зайлуулах, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг баталж, мөрдөж ажиллаж байна уу?

Уул уурхайн компаниуд хог хаягдлын менежментийн төлөвлөгөө гаргасан боловч хэрэгжилт нь холбогдох хууль журамд заасан шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Уул уурхайн компаниуд нь байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг тусган ажиллаж байна. Тухайлбал:

"Имприал гоулд майнинг" ХХК нь "Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө"-д арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөн биелэлтийг тайлагнан ажилласан байна. Аюултай хог хаягдлын хувьд сумын эмнэлэгтэй хамтран ажиллан аюултай хог хаягдал булшлах цэгт хүргэн ажиллажээ. Ажилчдын шингэн хог хаягдлыг ариутгах журмаар био ариутгагчийг тогтмол хэрэглэж байна.

Мэргэжлийн байгууллагын улсын байцаагчийн хяналтын хуудсыг авч үзэхэд хог хаягдлын менежментийн төлөвлөгөө гаргаагүй үйл ажиллагаа явуулж буй зөрчил илэрсэн байна.

Хүснэгт № 3. Хог хаягдалд хяналт хийсэн шалгах хуудас

Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлсэн орлого, орон нутагт хийсэн хөрөнгө оруулалт түүний үр ашиг

№	Шалгалт хийсэн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	"Баяжер минерал ресурс" ХХК	"Жи энд юу голд" ХХК	"Монгол болгар гео" ХХК	"Секер ресурс" ХХК	"Топ ган дрилинг" ХХК	"Хонгорын хүдэр" ХХК	"Наран мандал" ХХК	"Шижир аранжин" ХХК	"Эрдэнэ Монгол" ХХК
1	Энгийн хог хаягдлыг ангилан ялгадаг, шаардлага хангасан зориулалтын хогийн савтай	1	0	0	1	0	1	1	0	1
2	Ахуйн хог хаягдлаа цуглуулах, тээвэрлэх эрх бүхий байгууллага болон тогтоосон цэгт хүлээлгэн өгдөг	1	1	1	1	1	1	1	0	1
3	Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлж, гэрээний хэрэгжилтийг ханган ажилладаг	1	1	1	1	1	1	1	0	1
4	Хог хаягдлын гэрээ байгуулах, хяналт тавих, гадаад дотоод орчны цэвэрлэгээ, хариуцсан нэгж ажилтантай	0	1	0	1	1	1	1	1	1
5	Аюултай хог хаягдлыг үүсгэгчээр бүртгүүлж бүртгэлийн дугаар авсан		1	1	1	1	1	1	1	1
6	Аюулгүй хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр төрөл бүрээр бүртгэсэн.	1	1	0	0	1	1	1	0	1
7	Аюулгүй хог хаягдлаа эрх бүхий байгууллагад шилжүүлэх хүртэл түр аюулгүй нөхцөлийг бүрдүүлсэн орчинд хуулийн хугацаанд хадгалсан	1	1	1	1	0	1	1	1	1
8	Аюулгүй хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгдөг	1	0	0	1	0	1	1	0	1
9	Химийн бодис тээвэрлэхдээ тухайн бодист тохирсон ослын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулсан, шаардагдах багаж хэрэгслээр хангасан	1	x	x	x	x	x	x	x	x
10	Уурхайн хаягдлын далангийн аюулгүй байдал, хяналт шинжилгээний үр дүн	1	1	1	1	0	1	1	0	1
11	Химийн бодисыг хор аюулын лавлах мэдээлэлд заасан нөхцөлд тээвэрлэсэн	1	x	x	x	x	x	x	x	x
12	Химийн бодисын анхааруулах, аюулын тухай санамжийг байршуулсан зориулалтын тээврийн хэрэгслээр тээвэрлэдэг	1	x		x	x	x	x	x	x
	1- Зөрчилгүй		0- Зөрчилтэй		x-хамааралгүй					

Улсын байцаагчийн хяналтаар илэрсэн зөрчлийг хэрхэн арилгасан талаар биелэлтийн тайлан байхгүй тул зөрчилтэй буюу шаардлагад нийцээгүй үзүүлэлтийг дахин үнэлж, хяналтыг хэрэгжүүлэн үр дүнг ирүүлэх албан шаардлагыг аймгийн БОАЖГ-т хүргүүлэв.

А.3.2. Экологийн тэнцвэрт байдал, байгаль орчны талаар төрийн байгууллага хяналт хэрэгжүүлж байна уу?

Төрийн байгууллагуудаас хяналт хэрэгжүүлсэн хэдий ч биологийн нөхөн сэргээлт хангалтгүй, гэрээний үүргээ бүрэн биелүүлээгүй зэрэг нь хяналтын үр дүнг бууруулж байна.

Байгаль орчны хууль тогтоомжийн хэрэгжилтэд 2023 онд холбогдох төрийн байгууллагаас хяналт шалгалт хийхэд дараах нийтлэг зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, дүүргэлт хийж хэлбэржүүлэлт хийж байгаа боловч шаардлагад бүрэн нийцээгүй
- Биологийн нөхөн сэргээлт буюу ургамалжуулалт хангалттай бус
- Шимт хөрсийг тусгай талбайд овоолж хамгаалаагүй
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд туссан зарим ажлыг хийж гүйцэтгэдэггүй, өөрчлөлт тодотгол хийж эрх бүхий байгууллагаар хянуулж батлуулаагүй
- Аюултай хог хаягдлын бүртгэл мэдээлэл хөтөлдөггүй

Нэгэнт хариуцлагатай уул уурхайг ажиллуулах талаар төрөөс болон орон нутгийн түвшинд бодлого баримталж ажиллуулж байгаа хэдий ч байгаль орчинд сөргөөр нөлөөлөх, нөхөн сэргээх арга хэмжээ хангалттай түвшинд хийхгүй зөрчил арилахгүй байгаа нь хяналт шалгалтаар илэрснээс үзэхэд цаашид байгаль орчинд аюул хохирол нэмэгдэх эрсдэлтэй байна.

Иймд байгаль орчинд хохирол учруулж буй (биологийн нөхөн сэргээлтийг хийхгүй байгаа) уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй дахин гэрээ байгуулах эсэх асуудлыг авч үзэн экологийн тэнцвэрт байдлыг нэн тэргүүнд тавьж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/400 дугаар захирамжаар аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Вестурнресурс” ХХК, “Ар эс и” ХХК-иудын үйл ажиллагаанд 6 чиглэлээр хяналт шалгалтыг зохион байгуулж, чиглэл тус бүрээр зөрчил илрүүлэн 10 төрлийн зөвлөмжийг өгч биелэлтийг хангуулан ажилласан байна.

Мөн 2022 оны 10 дугаар сард Ашигт малтмал, газрын тосны газрын хайгуул, ашиглалтын газрын даргаар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Баянхонгор үйл ажиллагаа явуулж буй 16 тусгай зөвшөөрөл эзэмшигчид хяналт шалгалт хийн 8 төрлийн нийтлэг зөрчил илрүүлэн 14 төрлийн хариу арга хэмжээг авч ажиллан биелэлтийг хангуулж ажилласан байна.

Аймгийн Засаг дарга 2023 оны 5,8,12 дугаар саруудад 3 удаагийн захирамжаар ажлын хэсгийг томилон уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

Тус шалгалтын хүрээнд Баян-Овоо, Бөмбөгөр, Галуут сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй компаниудад нийтлэг 8 зөрчил илэрч 2.0 сая төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ авч ажилласан байна.

Харин 2023 оны 12 дугаар сард “Сэкер ресурс Монголиа” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн ба тус хяналтаар геологи уул уурхай чиглэлээр 6, Байгаль орчны чиглэлээр 4, авто зам тээврийн хяналтаар 6 зөрчил илэрсэн тул Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2² дахь заалтын дагуу илэрсэн зөрчлийг арилгахаар улсын байцаагчийн акт, албан шаардлагыг өгч үйл ажиллагааг зөрчлийг арилгах хүртэл хугацаанд түр зогсоох шийдвэр гаргасан байна.

БОАЖГ-аас улсын байцаагчийн хяналт шалгалтыг 2023 онд 10 аж ахуйн нэгжүүдэд хийсэн бөгөөд хяналт шалгалтаар стандарт хууль журамд нийцээгүй асуудлыг шалгах хуудсаар дүгнэж зөрчлийг тухай бүр арилгуулсан ба зөрчил тухай

² харьяалах нутаг дэвсгэрт нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг зориулалтаар ашиглуулах, зөрчил гаргавал таслан зогсоох

бүр шийдвэрлэгдээгүй асуудалд акт, албан шаардлага өгч биелэлтийг тооцож ажилласан байна.

БҮЛЭГ Б. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН ОРЛОГЫГ ОНОВЧТОЙ ТӨЛӨВЛӨЖ, ТӨСӨВТ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛСЭН ҮҮ?

ДҮГНЭЛТ Б. УУЛ УУРХАЙН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖҮҮДЭЭС ОРОХ ОРЛОГЫГ ТӨЛӨВЛӨХДӨӨ ХИЙСЭН ТООЦООЛОЛД ҮНДЭСЛЭЭГҮЙ, ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН УЯЛДАА ХОЛБООНООС ШАЛТГААЛАН ЗӨРҮҮТЭЙ НОГДУУЛСАН БАЙНА.

Б.1. Уул уурхайн салбарын төсвийн орлогыг нэр төрөл, тоо хэмжээгээр төлөвлөж, холбогдох хууль тогтоомжийн дагуу ногдуулж байна уу?

Б.1. Уул уурхайн салбарын ААН-үүдийн татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

Б.1.1. Уул уурхайн аж ахуйн нэгжүүд 2022, 2023 оны татварын орлогыг нэр төрөл, тоо хэмжээгээр үнэн зөв төлөвлөсөн үү?

Баянхонгор аймагт тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн ААН-үүдээс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөхгүй байна.

Баянхонгор аймагт тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүд нь орон нутгийн төсөвт, газрын болон усны төлбөр, хог хаягдлын хураамжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлдэг.

Баянхонгор аймгийн 2022, 2023 оны орон нутгийн төсвийн төсөлд уул уурхайн ААН-үүдээс орох газрын болон усны төлбөрийг төлөвлөхдөө сүүлийн 3-5 жилийн орлогын гүйцэтгэлд үндэслэн дараах байдлаар тооцсон байна.

Хүснэгт № 4. Газрын төлбөрийн 2022, 2023 оны төсвийн төслийн тооцоолол

Он	Төлбөр ногдох талбайн хэмжээ, га		Төлбөр ногдох орлого, (сая.төг)		Суурь орлого, (сая.төг)		Төлвөл зохих төлбөр, (сая.төг)		Төлсөн төлбөр, (сая.төг)	
	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023
2017	14,644	-	74.9	-	74.9	-	74.9	-	98.5	-
2018	36,348	36,348	74.9	74.9	74.9	74.9	74.9	74.9	73.0	98.4
2019	17,635	17,635	149.6	149.6	149.6	149.6	149.6	149.6	200.0	158.8
2020	16,407	16,251	144.8	134.7	144.8	134.7	144.8	134.7	155.1	-
2021	16,254	18,575	203.5	594.4	202.4	594.4	197.5	207.4	227.7	352.1
2022 оны санал	16,254	-	203.5	-	202.4	-	197.5	-	-	-
2022 оны санал	-	18,196	-	436.7	-	436.7	-	380.1	-	70.8
2023 оны санал	-	18,195	-	436.7	-	436.7	-	380.1	-	-

Эх сурвалж: Баянхонгор аймгийн орон нутгийн орлогын 2022, 2023 оны төсвийн төсөл

Хүснэгт № 5. Усны төлбөрийн 2022, 2023 оны төсвийн төслийн тооцоолол

Он	Уул уурхайн аж ахуйн нэгжийн тоо		Ашиглах усны хэмжээ, м3		Төлвөл зохих татвар (сая.төг)		Төлсөн төлбөр (сая.төг)	
	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023
2018	-	10	-	1,064,718	-	859.8	-	104.2
2019	12	12	1,720,519	1,720,519	817.6	817.6	166.5	166.5
2020	11	11	776,450	776,450	624.5	624.5	538.2	418.2
2021	8	13	851,415	965,396	717.5	399.2	98.7	379.4
2022	-	20	-	1,168,428	-	833.8	-	162.6

Эх сурвалж: Баянхонгор аймгийн орон нутгийн орлогын 2023 оны төсвийн төслийн тооцоолол

Сумдын ИТХ-ын тогтоолоор хог хаягдлын хураамжийн хэмжээг батлахдаа Шинэжинст, Баянговь, Баян-Овоо, Бөмбөгөр, Жинст, Заг, Өлзийт сумдууд уул уурхайн хог хаягдлыг хураамжийг тусган баталсан байна.

Аудитын илрүүлэлт:

✓ Сумдын ИТХ-ын тогтоолоор уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүдээс төвлөрөх хог хаягдлын хураамжийн хэмжээг баталсан байхад аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс нь 2019-2023 оны төсвийн төсөлд хог хаягдлын хураамжийн орлогыг тооцож төсвийн төсөлд тусгаагүй байна.

Иймд цаашид Баянхонгор аймагт тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн ААН-үүдээс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж байх албан шаардлагыг аймгийн ЗДТГ-ын СТСХ-т хүргүүлэв.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ нь Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөлтэй уул уурхайн ААН-үүдээс 2022, 2023 онд төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг аймаг, сумын төсвийн орлогын бүрэлдэхүүнд оруулахаар төлөвлөсөн байна. Үүнд:

Газрын төлбөрийн орлогыг 2023 оны төсвийн төсөлд 380.1 сая төгрөг орохоор тооцоолсон атлаа 278.1 сая төгрөгөөр Сангийн яамд хянуулсан.

Хүснэгт № 6. Уул уурхайн ААН-үүдийн татварын орлогын төсвийн төсөл

№	Орлогын төрөл	Орон нутгийн орлогын 2022 оны төсвийн төлөвлөлт (сая.төг)		Хянасан төсөв	Орон нутгийн орлогын 2023 оны төсвийн төлөвлөлт (сая.төг)		Хянасан төсөв
		Төсвийн төлөвлөлт	Үүнээс уурхайгаас		Төсвийн төлөвлөлт	Үүнээс уурхайгаас	
1	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	250.0	240.0	580.0	310.0	300.0	440.0
2	Газрын төлбөр	270.0	135.5	460.0	424.7	278.2	460.0
	Нийт дүн	520.0	375.5	1,040.0	734.7	578.2	900.0

Эх сурвалж: Баянхонгор аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн 2022, 2023 оны төсвийн төсөл

Б.1.2. Аж ахуйн нэгжүүд татварын ногдуулалтыг үнэн зөв хийж байна уу?

Ашигт малтмал, газрын тосны газар болон Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын мэдээллийн системийн зөрүүтэй байдлаас шалтгаалан газрын төлбөрийн ногдуулалт үнэн зөв хийгдэхгүй байна.

Баянхонгор аймагт ашиглалтын 97 тусгай зөвшөөрөл, хайгуулын 38 тусгай зөвшөөрөл эзэмшигч бүртгэлтэй ба Баянхонгор аймгийн нийт газар нутгийн 3.2 хувь буюу 366,919.25 га талбайг эзэлж байна.

Хүснэгт № 7. Баянхонгор аймгийн тусгай зөвшөөрөл сумдаар

№	Сумын нэр	Тусгай зөвшөөрлийн тоо		№	Сумын нэр	Тусгай зөвшөөрлийн тоо	
		Ашиглалт	Хайгуул			Ашиглалт	Хайгуул
1	Баацагаан	-	1	14	Заг	1	-
2	Баянбулаг	1	-	15	Өлзийт	1	1

Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлсэн орлого, орон нутагт хийсэн хөрөнгө оруулалт түүний үр ашиг

3	Баянговь	4	2	16	Хүрээмарад	1	-
4	Баянлиг	1	1	17	Шинэжинст	15	3
5	Баян-Овоо	10	5	18	Баацаган, Баянцагаан	-	1
6	Баян-Өндөр	6	2	19	Баацагаан, Бөмбөгөр	-	2
7	Баянцагаан	1	4	20	Баянговь, Шинэжинст	1	-
8	Бөмбөгөр	20	5	21	Баян-Овоо, Бөмбөгөр	2	2
9	Бууцагаан	1	2	22	Баян-Овоо, Галуут	1	1
10	Галуут	11	-	23	Баян-Өндөр, Шинэжинст	3	3
11	Гурванбулаг	8	-	24	Баянцагаан, Жинст	-	1
12	Жаргалант	5	-	25	Бууцагаан, Бөмбөгөр	2	-
13	Жинст	1	-	26	Өлзийт, Нарийн тээл	1	2
Нийт						97	38

Эх сурвалж: АМГТГ-ын мэдээллийн систем

Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ордод бал чулууны орд 1, төмрийн орд 2, зэс, молибдений орд 7, нүүрсний орд 15 байгаа бол алтны үндсэн болон шороон орд 72 буюу нийт ашиглалтын тусгай зөвшөөрлийн 74.0 хувийг эзэлж байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс 2022 онд 27 талбайд 16 ААН, 2023 онд 28 талбайд 23 ААН (1-12 сар хугацаанд) үйл ажиллагаа явуулсан нь судалгаагаар гарч байна.

Газрын төлбөр.

Ашигт малтмал, газрын тосны газрын бүртгэлийн системд (mpram.gov.mn) Баянхонгор аймагт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 152,810 га талбайн 97 нэгж талбар бүртгэлтэйгээс 28,919 га талбай бүхий 33 нэгж талбарын 22,906 га талбайг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын ГУМС-д (egazar.gov.mn) бүртгэсэн байна.

Баянхонгор аймагт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 123,891 га талбайн 64 нэгж талбарыг ГУМС-д бүртгэгдээгүй нь дараах шалтгаантай байна.

- Засгийн газрын 2020 оны “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай” 110 дугаар тогтоолын 4 дэх хэсэгт “Ашигт малтмалын ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөл, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу болон бичил уурхай эрхлэх зориулалтаар ашиглах талбайн мэдээллийг газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системд тухай бүр бүртгэж байхыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай” гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй.
- Ашиглалтын үйл ажиллагаа явуулж эхлээгүйтэй холбоотой тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүд тухай суманд хүсэлтээ өгч бүртгүүлдэггүйгээс эрх зүйн харилцаа үүсээгүй байна.
- Ашиглалтын үйл ажиллагаа явуулахаар уул уурхайн ААН-үүд хүсэлтээ өгдөг боловч тухайн сумд уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөггүйгээс сумын ИТХ, Засаг дарга нар холбогдох шийдвэрийг гаргадаггүйтэй холбоотой байна.

Ашигт малтмалын тухай хууль дагуу тусгай зөвшөөрлөөр эдэлбэр газар олгосон боловч дээрх шалтгааны улмаас эрх зүйн харилцаа үүсээгүй газарт төлбөр ногдуулах үндэслэлгүй байна.

Иймд газрын төлбөрийн орлого нь Ашигт малтмал, газрын тосны газар болон Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын мэдээллийн системийн

зөрүүтэй байдлаас шалтгаалан дутуу ногдож байгаа тул асуудлыг холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлэх саналыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газарт уламжлав.

Сумдын Засаг дарга нар газар ашиглуулах захирамж гаргахдаа лицензийн талбайгаар бус ашиглаж байгаа талбайн хэмжээгээр захирамж гаргаснаас ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн ААН-үүдийн мэдээллийг ГУМС-д дутуу бүртгэж газар ашиглах талбайн зөрүү гарсан байна. Тухайлбал:

Хүснэгт № 8. Талбайн хэмжээ зөрүүтэй ААН-ийн жагсаалт

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Лицензтэй талбайн хэмжээ, га	Ногдол хийгдсэн талбайн хэмжээ, га	Зөрүү га
1	Баян-Овоо	"Наран мандал энтерпрайзес" ХХК	MV-006720	755.2	90.4	664.8
2	Баян-Овоо	"Наран мандал энтерпрайзес" ХХК	MV-006907	298.1	139.2	159.0
3	Бөмбөгөр	"Ододгоулд" ХХК	MV-006853	174.2	128.9	45.3
4	Бууцагаан	"Ододгоулд" ХХК	MV-004960	169.2	158.1	11.1
5	Галуут	"Шижир-Аранжин" ХХК	MV-012665	108.8	91.6	17.1
Нийт				1,505.5	608.2	897.3

Эх сурвалж: Аудитын тулгалт


Тусгай зөвшөөрөл нь 2 сумын нутаг дамнан оршдог ашиглалтын тусгай зөвшөөрлийн ногдолыг нэг сум нь үүсгэсэн байхад нөгөө сум нь үүсгээгүйгээс ГУМС-д бүртгээгүйгээс 2 лицензийн талбайн 204.8 га талбайд ногдол хийгдээгүй байна. Үүнд:

Бөмбөгөр, Бууцагаан сумын нутагт MV-007468 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Одод гоулд" ХХК-ийн 75.2 га талбайн 24.4 га талбайг Бөмбөгөр сум ГУМС-д бүртгэсэн байхад Бууцагаан сум 50.7 га талбайг ГУМС-д бүртгээгүй байна.

Зураг № 1. "Одод гоулд" ХХК-ийн MV-007468 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай




АМГТГ-ын цахим систем




Газрын удирдлагын цахим систем

Бөмбөгөр, Баян-Овоо сумын нутагт MV-021059 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Эл Ти Ди" ХХК-ийн 574.3 га талбайн 420.4 га талбайг Бөмбөгөр сум ГУМС-д бүртгэсэн байхад Баян-Овоо сум 153.8 га талбайг ГУМС-д бүртгээгүй байна.

Зураг № 1. "Эл Ти Ди" ХХК-ийн MV-021059 ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай



АМГТГ-ын цахим систем



Газрын удирдлагын цахим систем

Аудитын илрүүлэлт:

- ✓ Сумдын Газрын даамал ГУМС-д талбайн хэмжээг дутуу оруулснаас ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг 5 ААН-ийн 897.3 га талбайд, тусгай зөвшөөрөл нь 2 сумын нутаг дамнан оршдог ашиглалтын тусгай зөвшөөрлийн ногдлыг нэг сум нь үүсгэсэн байхад нөгөө сум нь үүсгээгүйгээс ГУМС-д бүртгээгүйгээс 2 лицензийн талбайн 204.8 га талбай нийт 1,102.1 га талбайд ногдол хийгдээгүй байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийг 23.3³, 23.3.8⁴, 23.4⁵, 23.4.5⁶ дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Баянхонгор аймгийн ГХБХБГ-т Газрын удирдлагын мэдээллийн санд дээрх 7 ААН-ийн талбайн хэмжээг нөхөн мэдээлж ногдлыг үнэн зөв хийх албан шаардлагыг хүргүүлэв.

Шинэжинст сумын Засаг даргын 2011 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн “Газар эзэмшүүлэх тухай” 45 дугаар захирамжаар “Гоби коул энд энерги” ХХК-д 2 дугаар багийн Хотгор дэрсний уурхай орчмын 819 га газрыг дэд бүтэц, барилга байгуулам барих зориулалтаар, 2012 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн “Газар эзэмшүүлэх тухай” 34 дүгээр захирамжаар “Гоби коул энд энерги” ХХК-д 2 дугаар багийн нутагт Хонхор дэрсний нүүрсний уурхайн ашиглалтад зориулан цахилгаан станц, нүүрс угаах үйлдвэр, дэд бүтэц барилга байгууламж барих зориулалтаар 2 хэсэг 285 га, 2012 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн “Газар эзэмшүүлэх тухай” 68 дугаар захирамжаар “Гоби коул энд энерги” ХХК-д 1,162 га газар тус тус эзэмшүүлсэн байна.

Өмнөх захирамжаар эзэмшүүлсэн 2,266 га газраас Шинэжинст сумын Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн “Эзэмшил газрын талбайн хэмжээг өөрчлөх тухай” А/08 дугаар захирамжаар “Гоби коул энд энерги” ХХК-д үйлдвэр, дэд бүтцийн зориулалтаар эзэмшүүлсэн газруудаас сумын хөгжлийн ерөнхий

³ - Аймаг, нийслэлийн газрын алба дараахь эрх хэмжээтэй байна

⁴ - Газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу тодорхойлж ногдуулах

⁵ - Сумын газрын даамал, дүүргийн газрын алба дараахь эрх хэмжээтэй байна

⁶ - Газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу тодорхойлж ногдуулах


төлөвлөгөөтэй давхацсан газруудыг хэсэгчлэн хасаж, үдэгдэл 830 га газрыг үргэлжүүлэн эзэмшүүлсэн байна.

Баянхонгор аймгийн Шинэжинст суманд ашиглалтын 7 тусгай зөвшөөрөлтэй “Сэкер ресурс монголиа” ХХК-ийн талбайг ГУМС-д бүртгэхдээ лицензийн талбайнуудыг давхцуулан 11 талбай болгож бүртгэсэн байна.

Зураг № 1. “Сэкер ресурс монголиа” ХХК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай



АМГТГ-ын цахим систем



Газрын удирдлагын цахим систем

Аудитын илрүүлэлт:

✓ Баянхонгор аймгийн Шинэжинст суманд үйл ажиллагаа явуулж буй “Сэкер ресурс монголиа” ХХК-ийн ашиглалтын 7 тусгай зөвшөөрлийн талбайн газар ашиглах захирамжийг Шинэжинст сумын Засаг дарга 11 талбай болгож зөрүүтэй гаргаснаас шалтгаалан сумын газрын даамал Газрын удирдлагын мэдээллийн системд зөрүүтэй бүртгэсэн байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3⁷, 23.3.3⁸, 23.4⁹, 23.4.3¹⁰ дахь заалтуудыг зөрчсөн байна.

Иймд дээрх зөрүүтэй бүртгэсэн 7 лицензийн талбайн зөрүүг гаргаж зөв бүртгэх албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

Хог хаягдлын хураамж.

Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаг тусгай зөвшөөрөлтэй 19 ААН-тэй 2022 онд 18.0 сая, 11 ААН-тэй 2023 онд 12.2 сая төгрөгийн Хог хаягдлын гэрээг байгуулсан байна. Гүйцэтгэлээр уул уурхайн ААН-үүдээс 2022 онд 17.3 сая, 2023 онд 11.8 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

Хүснэгт № 9. Хог хаягдлын хураамжийн ногдол, гүйцэтгэл

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	2022 он (сая.төг)			2023 он (сая.төг)		
			Ногдол	Төлсөн	Зөрүү	Ногдол	Төлсөн	Зөрүү

⁷ - Аймаг, нийслэлийн газрын алба дараах эрх хэмжээтэй байна

⁸ - Газрын кадастр эрхлэх, аймаг, нийслэлийн газрын мэдээллийн сан байгуулж, олон нийтэд мэдээллээр үйлчлэх

⁹ - Сумын газрын даамал, дүүргийн газрын алба дараах эрх хэмжээтэй байна

¹⁰ - Эзэмшил, ашиглалтад олгогдсон газрын хэмжээ заагийг газар дээр нь тэмдэгжүүлж, координатжуулах, тэдгээрийн кадастрын зургийг үйлдэж, газрын улсын бүртгэлд бүртгэх

Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлсэн орлого, орон нутагт хийсэн хөрөнгө оруулалт түүний үр ашиг								
1	Баян-Овоо	"Наран мандал энтерпрайзес" ХХК	1.2	1.2	-	1.2	1.2	-
2	Баян-Овоо	"Станхолдинг" ХХК	0.8	0.8	-	1.2	1.2	-
3	Бөмбөгөр	"Эл Ти Ди" ХХК	1.0	0.6	0.4	-	-	-
4	Бөмбөгөр	"Ододгоулд" ХХК	0.2	0.2	-	-	-	-
5	Бөмбөгөр	"Ай эн ди" ХХК	0.8	0.8	-	1.0	0.6	0.4
6	Бөмбөгөр	"Вояжер Минерал Ресурсес" ХХК	2.4	2.4	-	2.4	2.4	-
7	Бөмбөгөр	"Хишигт хөндий" ХХК	0.6	0.6	-	-	-	-
8	Бөмбөгөр	"Эрдэнэ цагаач" ХХК	-	-	-	1.0	1.0	-
9	Бөмбөгөр	"Ти энд Ти юникс" ХХК	0.6	0.6	-	-	-	-
10	Галуут	"Баялаг-Орд" ХХК	1.2	1.2	-	-	-	-
11	Галуут	"Шижир-Аранжин" ХХК	1.2	1.2	-	1.2	1.2	-
12	Галуут	"Монголболгаргео" ХХК	1.2	1.2	-	1.2	1.2	-
13	Галуут	"Ар Эс И" ХХК	1.2	1.2	-	-	-	-
14	Галуут	"Вестернресурс" ХХК	1.0	1.0	-	-	-	-
15	Галуут	"Топ ган дриллинг" ХХК	3.0	3.0	-	1.5	1.5	-
16	Шинэжинст	"Сэкер ресурс монголиа" ХХК	0.3	0.3	-	-	-	-
17	Шинэжинст	"Анианресорсиз" ХХК	-	-	-	0.6	0.6	-
18	Шинэжинст	"Эрдэнэмонгол" ХХК	0.3	-	0.3	0.6	0.6	-
19	Шинэжинст	"Эрдэнэс алт ресурс" ХХК	0.4	0.4	-	-	-	-
20	Шинэжинст	"Баян хөх толгой" ХХК	0.4	0.4	-	-	-	-
21	Жинст	"Лүтайрөүд констракшн" ХХК	0.3	0.3	-	0.3	0.3	-
Нийт			18.0	17.3	0.7	12.2	11.8	0.4

Эх сурвалж: Аудитын тулгалт

Аудитын илрүүлэлт:

✓ Гурванбулаг сумын ИТХ-ын 2021 оны 4 дүгээр хуралдааны 4/04 дүгээр тогтоолоор "Сумын хог хаягдал гаргаасны төлбөрийн хэмжээ"-г батлахдаа уул уурхайн ААН-үүдээс авах хог хаягдлын хэмжээг тусгаггүй орхигдуулснаас ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй "Жи энд Юу голд" ХХК-аас 2022, 2023 онд хог хаягдлын хураамжийг аваагүй байна.

Иймд уул уурхайн ААН-үүдээс оруулах хог хаягдлын хураамжийн төлбөрийн хэмжээг сумын ИТХ-аар батлуулж, орон нутгийн орлогыг нэмэгдүүлж ажиллах албан шаардлагыг Гурванбулаг сумын Засаг даргад хүргүүлэв.

Усны төлбөр.

Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаа нь уул уурайн ашиглагч байгууллагуудаас ус ашигласан тайланг хүлээн авч, тоолуурын заалт батлагаажуулсан акт болон тоолуур салгасан актыг үндэслэн усны ногдуулалтыг хийж татварын байгууллагад хүргүүлсэн байна.

Хүснэгт № 10. Бөөнцагаан Орог нуурын сав газрын захиргаанаас аймгийн Татварын хэлтэст хүргүүлсэн усны төлбөрийн ногдуулалт

№	Ус ашиглагчийн нэр	Усны ногдуулалт	
		2022 он	2023 он
1	"Наран Мандал Энтерпрайзес" ХХК	98.9	104.6
2	"Эл Ти Ди" ХХК	29.2	0

Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлсэн орлого, орон нутагт хийсэн хөрөнгө оруулалт түүний үр ашиг

3	"Вестернресурс" ХХК	66.2	0
4	"Би Эс Ай" ХХК	35.1	32.9
5	"Топ ган дриллинг" ХХК	87.7	35.8
6	"Вояжер Минериал Ресурсес" ХХК	2.6	9.6
7	"Ай Эн Ди" ХХК	4.3	33.8
8	"Одод Гоулд" ХХК	6.7	0
9	"Ти Энд Ти Юникс" ХХК	4.2	0
10	"Шижир-Аранжин" ХХК	17.2	20.3
11	"Хишиг Хөндий" ХХК	43.7	0
12	"Стархолдинг" ХХК	44.6	24.3
13	"Монголболгаргео" ХХК	35.3	0
14	"Женри" ХХК	13.9	0
15	"Эрдэнэ цагаач" ХХК	0	4.5
	Дүн	489.3	265.8

Аудитаар ус ашигласан тайлан тоолуур баталгаажуулсан заалтыг тулгаж үзэхэд зөрүүгүй тохирч байна.

Б.2. Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт иж бүрэн байна уу?

Б.2. Уул уурхайн салбараас төсөвт төвлөрүүлэх татварын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Б.2.1. Төлөвлөсөн орлогыг хугацаанд нь төсөвт бүрэн төвлөрүүлсэн үү?

Газрын төлбөр, хаягдлын хураамжийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Баянхонгор аймгийн сумдын газрын төлбөрийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 6/25 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар "Хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэл"-ийн зориулалттай газрын суурь үнэ 16.0 сая төгрөгөөс 0.15 хувиар тооцон нэг га талбайн төлбөрийг 24,000 төгрөгөөр тогтоосон байна.

Баянхонгор аймагт уул уурхайн ААН-үүдээс орон нутгийн төсөвт 2022 онд газрын төлбөрөөс 296.7 сая, хог хаягдлын хураамжаас 17.3 сая, усны төлбөрөөс 553.0 сая, 2023 онд газрын төлбөрөөс 464.0 сая, хог хаягдлын хураамжаас 11.8 сая, усны төлбөрөөс 395.3 сая төгрөгийн орлогыг тус тус төвлөрүүлсэн байна.

Хүснэгт № 11. Татварын орлогын 2022, 2023 оны ногдол, гүйцэтгэл

№	Татварын орлого	2022 он (сая.төг)			2023 он (сая.төг)		
		Ногдол	Төлсөн	Зөрүү	Ногдол	Төлсөн	Зөрүү
1	Газрын төлбөр	373.5	296.7	76.8	597.5	464.0	133.5
2	Хог хаягдлын хураамж	18.0	17.3	0.7	12.2	11.8	0.4
3	Усны төлбөр	581.2	553.0	28.2	430.0	395.3	37.4
	Нийт дүн	972.7	867.0	105.7	1039.7	871.1	170.9

Эх сурвалж: Аудитын тулгалт

Ашиглалтын үйл ажиллагааг 2022, 2023 онд явуулсан 7 ААН-ийн 74.1 сая, 2022, 2023 онд ашиглалтын үйл ажиллагаа явуулаагүй 4 ААН-ийн 136.2 сая нийт 210.3 сая төгрөгийн газрын төлбөрийн орлого дутуу төвлөрсөн байна.

Хүснэгт № 12. Газрын төлбөрийн орлого дутуу төлсөн ААН-ийн жагсаалт

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Дутуу төвлөрсөн газрын төлбөр (сая.төг)	
				2022 он	2023 он
2021, 2022 онд үйл ажиллагаа явуулсан					
1	Бөмбөгөр	"Эл ти ди" ХХК	MV-021059	-	10.1
2	Бөмбөгөр	"Ай эн ди" ХХК	MV-017405	-	20.7
3	Бөмбөгөр	"Эрдэнэ цагаач" ХХК	MV-020998	9.9	9.9
4	Галуут	"Империл гоулд майнинг" ХХК	MV-015643	0.2	-
5	Галуут	"Баялаг орд" ХХК	MV-000222	-	0.5
6	Галуут	"Вестернресурс" ХХК	MV-017495	2.8	6.8
7	Гурванбулаг	"Жи эс би ресурс" ХХК	MV-005411	6.6	6.7
	Дүн			19.5	54.7
2021, 2022 онд үйл ажиллагаа явуулаагүй					
1	Бөмбөгөр	"Шинэсансар" ХХК	MV-015170	40.4	40.4
2	Бөмбөгөр	"Эрдэнэминас" ХХК	MV-017507	-	19.1
3	Бөмбөгөр	"Мөнхийн номхон далай" ХХК	MV-021303	16.9	16.9
4	Гурванбулаг	"Жи энд юу голд" ХХК	MV-012806	-	2.4
	Дүн			57.3	78.8
	Нийт дүн			76.8	133.5

Эх сурвалж: Аудитын тулгалт

Сумын Засаг даргатай "Хог хаягдлын гэрээ" байгуулж ашиглалтын үйл ажиллагаа 2022, 2023 онд явуулсан 3 ААН 1.1 сая төгрөгийн хог хаягдлын хураамжийг дутуу төлсөн байна.

Хүснэгт № 13. Хог хаягдлын хураамжийн орлого дутуу төлсөн ААН-ийн жагсаалт

№	Сумын нэр	Аж ахуйн нэгжийн нэр	Тусгай зөвшөөрлийн дугаар	Дутуу төвлөрсөн хог хаягдлын хураамж (сая.төг)	
				2022 он	2023 он
1	Бөмбөгөр	"Эл ти ди" ХХК	MV-021059	0.4	-
2	Бөмбөгөр	"Ай эн ди" ХХК	MV-017405	-	0.4
3	Шинэжинст	"Эрдэнэ монгол" ХХК	MV-021444	0.3	-
	Нийт			0.7	0.4

Эх сурвалж: Аудитын тулгалт

Усны төлбөр

Усны төлбөрт 2022 оны эхний үлдэгдэл дутуу төвлөрсөн 39.9 сая төгрөг байсан бол 2023 оны жилийн эцсийн байдлаар 110.4 сая төгрөгийн усны төлбөрийг дутуу төвлөрүүлсэн байна.

Хүснэгт № 14. Усны төлбөр тооцоо

Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлсэн орлого, орон нутагт хийсэн хөрөнгө оруулалт түүний үр ашиг

№	Ус ашиглагчийн нэр	2022 оны эхний үлдэгдэл	2022 оны ногдуулалт	2022 онд төлсөн татвар	2022 оны эцсийн үлдэгдэл	2023 оны ногдуулалт	2023 онд төлсөн татвар	2023 оны эцсийн үлдэгдэл
1	"Топ ган дриллинг" ХХК	18.0	87.7	100.1	5.6	35.8	38.5	3.0
2	"Ай Эн Ди" ХХК	14.8	4.3	11.9	7.2	33.8	33.8	7.2
3	"Ти Энд Ти Юникс" ХХК	-	4.2	-	4.2	-	-	4.2
4	"Шижир-Аранжин" ХХК	6.5	17.2	19.8	3.9	20.3	20.3	3.9
5	"Хишигт хөндий" ХХК	-	43.7	-	43.7	-	-	43.7
6	"Стар холдинг" ХХК	-	44.6	10.0	34.6	-	-	34.6
7	"Женри" ХХК	-	13.9	-	13.9	-	-	13.9
	Нийт дүн	39.3	215.6	141.8	113.1	89.9	92.6	110.4

Эх үүсвэр: Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны усны төлбөр тооцооны баримтууд

Аудитын илрүүлэлт:

✓ Орон нутгийн төсөвт уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс газрын төлбөрийн орлогыг 2022 онд 76.8 сая, 2023 онд 133.5 сая, усны төлбөрийн орлогыг 2023 онд 110.4 сая, хог хаягдлын хураамжийг 2022 онд 0.7 сая, 2023 онд 0.4 сая нийт 321.8 сая төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1¹¹, Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5¹², 9 дүгээр зүйлийн 9.1¹³, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 23.2¹⁴ дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд дээрх дутуу төвлөрсөн газрын төлбөр 210.3 сая, хог хаягдлын хураамжийн 1.1 сая, усны төлбөрийн 110.4 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн актыг Баянхонгор аймгийн Татварын газарт хүргүүлэв.

Б.2.2. Уул уурхайн салбарын татварын орлого, хандив тусламжийг үнэн зөв бүртгэж, тайлагнасан уу?

Орон нутгийн орлогод 2022-2023 онд уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс газрын төлбөр, усны төлбөр, хог хаягдлын хураамжийн орлогыг бүртгэсэн бол 2023 онд 2,605.0 сая төгрөгийн хандивын орлогыг ОНХС-ийн эх үүсвэрээр бүртгэсэн байна.

Баянхонгор аймагт тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн ААН-үүдийн 2022, 2023 онд төсөвт төвлөрүүлсэн газрын төлбөр, усны төлбөр, хог хаягдлын хураамжийг төсвийн орлогын бүрэлдэхүүн хэсэгт оруулан Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлагнасан байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.10, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасны дагуу аймгийн Засаг дарга Баянхонгор аймагт ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 21 ААН-тэй (давхардсан тоогоор) 2022-2023 онд 1-3 жилийн хугацаанд

¹¹ - Газар эзэмшиж, ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага Газрын төлбөрийн тухай хуулийн дагуу газрын төлбөр төлнө

¹² - Газрын төлбөр төлөгч жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно

¹³ -Газрын төлбөрийг газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн тооцно

¹⁴ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогыг энэ хуулийн 23.1-д заасан этгээд дараа сарын 10-ны өдрийн дотор орон нутгийн төсөвт ногдуулан хурааж, төлбөрийн жилийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор харьяалагдах татварын албанд тушааж эцсийн тооцоо хийнэ.

хэрэгжүүлэх “Байгаль орчныг хамгаалах уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх” гэрээг байгуулсан бөгөөд гэрээнд 2022 онд аймагт 2,300.0 сая, суманд 1,155.0 сая, 2023 онд аймагт 1,925.0 сая, суманд 1,140.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр Баянхонгор аймагт уул уурхайн үйл ажиллагаа явуудаг ААН-үүд 2022 онд зам талбай, барилгын засвар, гудамж талбайн тохижилт, дэмжлэг, ажил, үйлчилгээ, бараа материалд 1,799.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Аймаг, сумдын ОНХС-д 2023 онд уул уурхайн ААН-үүдээс 2,605.0 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ В. УУЛ УУРХАЙН САЛБАРААС ОРОН НУТАГТ ХИЙХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ БОДИТОЙ ТӨЛӨВЛӨЖ, ҮР АШИГТАЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ҮҮ?

ДҮГНЭЛТ В. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУССАН ЗАРИМ АЖЛЫГ УУЛ УУРХАЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧДИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИЙДВЭРЛЭСЭН НЬ ҮР АШГАА ӨГЧ БАЙНА.

В.1. Уул уурхайн салбарын хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтууд төлөвлөсөн үр дүнд хүрсэн үү?

В.1. Баянхонгор аймгийн Хөгжлийн төлөвлөгөөнд 2022 онд тусгагдсан хөрөнгө оруулалтыг уул уурхайн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр болж байна.

В.1.1. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ нь орон нутагт нэн тэргүүнд хэрэгцээ шаардлагатай асуудлыг шийдвэрлэж чадаж байна уу?

Аймгийн хэмжээнд 2022-2023 онд уул уурхайн компаниудаас хийсэн 4,404.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, хандив нь орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулсан байна.

“Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг, аймгийн ИТХ-ын хуралдааны 2020 оны 2/6 дугаар тогтоолоор баталсан “Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д нийцүүлэн Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” 6/23 дугаар тогтоолоор 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг баталсан байна. Аймгийн ИТХ-ын хуралдааны 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 10/37 дугаар “Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол баталж хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 1,854.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 38 төсөл, арга хэмжээний 1,465.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг уул уурхайн аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалтаар хийсэн байна.

Өмнөх оны буюу 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 1,300.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 2 төсөл, арга хэмжээнд уул уурхайн аж ахуйн нэгж 331.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Аймгийн 2021, 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 31 төсөл арга хэмжээнээс орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн 1,291.2 сая төгрөгийн 17 хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Үүнд:

- ✓ Явган замын хавтангийн үйлдвэрт шаардлагатай явган замын болон блокны хэв, бусад бараа материалыг худалдаж авч өгөхөд уул уурхайн ААН-үүд 293.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь нэн хэрэгцээ шаардлагатай хөрөнгө оруулалт болсон байна.
- ✓ Төв замын 90 ширхэг, 2.7.9 дүгээр багийн 243 ширхэг гэрэлтүүлэгийн ажилд “Эрдэнэ монгол” ХХК 79.0 сая, “Наранмандал энтерпрайзес” ХХК 20.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.
- ✓ Шинэ суурьшлын бүсийн цэвэр, бохир усны цахилгаан, автоматжуулалт, шугам угсралт, цахилгааны угсралтын ажилд “Эрдэнэ монгол” ХХК 65.0 сая, ногоон байгууламж нэмэгдүүлэхэд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж худалдан авахад “Наранмандал энтерпрайзес” ХХК 30.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.
- ✓ Дөвөнтийн заал, Стандарт хэмжил зүйн хэлтэс, шүүхийн шинжилгээний албаны гадна засварын ажилд уул уурхайн ААН-үүд 107.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.
- ✓ Явган замын хавтангийн үйлдвэрт шаардлагатай явган замын болон блокны хэв, бусад бараа материалыг худалдаж авч өгөхөд “Эрдэнэ монгол” ХХК 50.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

В.1.2. Хөрөнгө оруулалтаар хийсэн төсөл, арга, хэмжээг норм, стандартын дагуу хийж гүйцэтгэсэн үү?

Уул уурхайн ААН-үүдийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээг мэргэжлийн байгууллагыг оролцуулсан комисс хүлээн авсан байна.

Нийт 78.8 сая төгрөгийн 2 барилгын засвар, 1 замын засвар, 1 тохижилтын ажил хийгдсэн ба ашиглагчийн шаардлагыг хангаж байна.

- ✓ “Вестерн ресурс” ХХК-ийн 28.8 сая төгрөгийн санхүүжилтээр Стандарт, хэмжил зүйн хэлтсийн барилгын гадна засварын ажлыг “Алтайн гурван нуур” ХХК гүйцэтгэсэн ба барилгын засвар хийгдснээр барилгын дулаан алдагдал багасаж ажилчдын ажиллах ая тухтай орчин бүрдсэн байна.
- ✓ “Наранмандал энтерпрайзес” ХХК-ийн 20.0 сая төгрөгийн санхүүжилтээр хог тээвэрлэлтийн үйл ажиллагааг саадгүй хийж гүйцэтгэх зорилгоор улсын чанартай авто замаас хогийн цэг хүртэлх 1.5 км сайжруулсан шороон замыг “Талын нөмөр” ХХК хийснээр Баянхонгор аймгийн “Цэвэр хот” ОНӨААТҮГ-ын хог тээврийн авто машинууд ажил үүргээ гүйцэтгэхэд саадгүй болсон байна.
- ✓ “Топ ган дриллинг” ХХК-ийн 10.0 сая төгрөгийн санхүүжилтээр Шүүхийн шинжилгээний албаны барилгын дотор болон гаднах засварын ажлыг албан хаагчид хийж гүйцэтгэсэн бөгөөд ажиллах орчин нөхцөл сайжирсан байна.
- ✓ “Эрдэнэ монгол” ХХК-ийн 20.0 сая төгрөгийн санхүүжилтээр Оготнотой булгийн тохижилтын ажлыг “Ган мөнхжин” ХХК гүйцэтгэсэн бөгөөд тус ажлын хүрээнд боржин чулуун сандал 15 ширхэг, боржин чулуун ширээ 2 хийгдснээр иргэд ая тухтай зугаалах нөхцөл бүрдсэн байна.

В.1.3. Хөрөнгө оруулалтаар хийсэн бүтээн байгуулалт нь орон нутагт үр ашгаа өгч байна уу?

Баянхонгор аймагт 2022 онд уул уурхайн ААН-үүдийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн бүтээн байгуулалт нь үр ашгаа өгч байна.

Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн ААН-үүдийн хөрөнгө оруулалтаар нийтийн эзэмлийн талбайн бүтээн байгуулалтууд хийсэн нь орон нутагт үр ашгаа өгч байна. Тухайлбал:

Оготнотой булгийг түшиглэсэн соёл, амралтын хүрээлэн



Уг цогцолборын хөрөнгө оруулалтыг уул уурхайн аж ахуй нэгжүүд болон бусад эх үүсвэрээс шийдвэрлэсэн байна. Үүнд:

- ❖ Волейболын талбай
- ❖ Сагсан бөмбөгийн талбай
- ❖ Хүүхдийн тоглоомын талбай
- ❖ Мөсөн талбай
- ❖ Крикитийн талбай
- ❖ Дугуйн зам
- ❖ Авто зогсоол

Соёл, амралтын хүрээлэн ашиглалтад орсноор Баянхонгор аймгийн ард иргэдийн эрүүл идэвхитэй амьдрах, спортоор хичээллэх сонирхол нэмэгдэж, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх нөхцөл боломж бүрдсэн байна.

Шинэ суурьшлын бүсийн мод үржүүлгийн газарт 32 төрлийн багаж, тоног төхөөрөмж, 3 төрлийн 40,000 ширхэг харандаа суулгац, 3 төрлийн 17 кг модны үр, 2 төрлийн 19,450 ширхэг тарьц суулгацын дэмжлэг үзүүлсэн нь цаашид ногоон байгууламжийг нэмэгдүүлэх боломж бүрдсэн байна.

Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүс



Мөн дараах бүтээн байгуулалтууд үр ашгаа өгч байна.

- ❖ Явган замын хавтангийн үйлдвэрт шаардлагатай явган замын болон блокны хэв, бусад бараа материалыг худалдаж авч, үйл ажиллагааг сайжруулснаар Баянхонгор аймгийн ХХҮГ-т бүртгэлтэй ажил эрхлэх хүсэлтэй давхардсан тоогоор 423 иргэнийг түр ажлын бараар ханган 2022 онд 18,446 ширхэг эко хавтан, 9,786 ширхэг явган замын хашлага үйлдвэрлэн 15,644.3 мкв талбайг явган замын хавтангаар хучиж Баянхонгор хотын тоосжилтыг бууруулж ажилласан байна.
- ❖ Дөвөнтийн заалны засвар хийгдснээр Номгон 1 дүгээр багийн үйл ажилагаа хэвийн явагдахаас гадна иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, спортоор хичээллэх орчин нөхцөл бүрдэхээс гадна спортоор хичээллэх иргэдийн тоо нэмэгдсэн байна.
- ❖ Үндэсний бөх, футзалны 21 аймгийн аварга шалгаруулах тэмцээн, Бадминтон, Крикетын Улсын аварга, Ламын эгээний Их тойром үндэсний шагайн харваа, Бодибилдинг, Монголын мастеруудын биеийн тамир спортын VI наадам зэрэг 7 арга хэмжээг зохион байгуулсан.
- ❖ Стандарт хэмжилзүйн хэлтсийн барилга, Шүүхийн шинжилгээний албаны барилгад засвар хийгдснээр албан хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирсан байна.

Баянхонгор аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн гаргасан уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтын үр ашгийн судалгаагаар хөрөнгө оруулалтаар хийгдсэн 14 бүтээн байгуулалтын үр ашгийг Баянхонгор аймгийн иргэд, хүүхэд багачууд хүртэж байна. Цаашид ногоон байгууламж нэмэгдэж, тоосжилт багасаж, ард, иргэд спортоор хичээллэж, эрүүл идэвхитэй амьдралын хэв маягийг хэвшил болгосноор өвчлөл буурах боломж харагдаж байна.

В.2. Уул уурхайн салбарын хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт ашиглалтад бүрэн орж бүртгэл тайланд тусгасан уу?

В.2. Уул уурхайн салбарын хөрөнгөөр хийгдсэн 307.4 сая төгрөгийн 3 хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.

В.2.1. Уул уурхайн салбарын хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт ашиглалтад бүрэн орсон уу?

Уул уурхайн ААН-үүдийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа 100.1 сая төгрөгийн нэг төсөл, арга хэмжээ дуусаагүй байна.

Баянхонгор аймагт уул уурхайн ААН-үүдийн санхүүжилтээр 2022 онд 1,317.1 сая төгрөгийн 15 хөрөнгө оруулалтын ажил, 78.8 сая төгрөгийн 4 засварын ажил, 148.3 сая төгрөгийн 7 ажил, үйлчилгээ, 148.0 сая төгрөгийн 7 дэмжлэг, 106.7 сая төгрөгийн 7 бараа материал худалдан авах хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн байна.

Хөрөнгө оруулалтын 1,037.1 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээ, 78.8 сая төгрөгийн 4 засварын ажил, 148.3 сая төгрөгийн 7 ажил, үйлчилгээг бүрэн хийж хүлээлгэн өгсөн, 106.7 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч нийлүүлсэн бөгөөд холбогдох 3 байгууллага бараа материалын тайланд бүртгэсэн байна.

Оготнотой булгийн хүүхдийн паркийн ажилд Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эрдэнэ монгол” ХХК-ийн 100.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Гүйцэтгэгч “Бенж цэс” ХХК уул уурхайн

хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлыг бүрэн хийж дууссан боловч орон нутгийн төсвөөр хэрэгжүүлж буй ажил дуусаагүй тул төсөл, арга хэмжээг хүлээн аваагүй байна.

В.2.2. Хэрэгжиж дууссан хөрөнгө оруулалтуудыг нягтлан бодох бүртгэлд бүрэн тусгасан уу?

Уул уурхайн ААН-үүдийн хөрөнгө оруулалтаар хийгдэж ашиглалтад орсон 307.4 сая төгрөгийн 3 хөрөнгийг нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.

Баянхонгор аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн “Үндсэн хөрөнгөд эзэмшигч тогтоох тухай” 13/11 дүгээр тогтоолоор уул уурхайн ААН-ийн 909.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хийгдэж ашиглалтад орсон 11 хөрөнгийн эзэмшигчийг тогтоож орлого авах шийдвэр гарсан байна.

Дээрх тогтоолоор уул уурхайн ААН-үүдийн 842.6 сая төгрөгийн санхүүжилт бүхий 1,616.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 10 хөрөнгийг 7 байгууллага үндсэн хөрөнгөд бүртгэсэн байна.

Эрдэнэмандал хайрханд мод тарих 107.1 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний модны ургац хангалтгүй, захиалагчтай байгуулсан гэрээний хугацаа дуусаагүй тул дансанд бүртгэх боломжгүй гэх тайлбарыг “Баянхонгор-тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 136 дугаар албан бичгээр аймгийн ОНӨГ-т хүргүүлсэн байна.

Баянхонгор аймагт уул уурхайн хөрөнгө оруулалтаар 2022 онд хийгдэж ашиглалтад орсон 307.4 сая төгрөгийн 3 хөрөнгийг эзэмшигч тогтоох эрх бүхий байгууллагын тогтоол гараагүйгээс нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй байна.

Хүснэгт № 15. Нягтлан бодох бүртгэлд бүртгээгүй хөрөнгө оруулалтын жагсаалт

№	Төсөл, арга хэмжээ	Уул уурхайн ААН	Хөрөнгө оруулалтын дүн (сая.төг)
1	Оготнотой булгийн сагсан бөмбөгийн талбай байгуулах	“Эрдэнэ монгол” ХХК	109.9
2	Оготнотой булгийн Мөсөн талбай байгуулах	“Эрдэнэ монгол” ХХК	147.5
3	Оготнотой булгийн авто зогсоолын өргөтгөл	“Топ ган дриллинг” ХХК	50.0
Нийт дүн			307.4

Эх сурвалж: Аймгийн ИТХ-ын тогтоол

Аудитын илрүүлэлт:

- ✓ Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж ашиглалтад оруулсан 3 төсөл, арга хэмжээний 307.4 сая төгрөгийн өртөг бүхий хөрөнгийн эзэмшигчийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар тогтоох шийдвэрийг аймгийн Орон нутгийн өмчийн газар гаргуулаагүйгээс нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1¹⁵, 6.1.4¹⁶, 6.2¹⁷, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4¹⁸ дэх заалтуудтай нийцэхгүй тул хөрөнгийн эзэмшигчийг тогтоож, данс бүртгэлд тусгах албан шаардлагыг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

Аудитаар нийт 629.2 сая төгрөгийн 11 зөрчил илэрч 321.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгах 307.4 сая төгрөгийн 7 албан шаардлага өгч, зөрчлийг давтан гаргуулахгүй байх 3 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

-oOo-

¹⁵ -Төрийн өмчид эд хөрөнгийг дараахь хэлбэрээр олж авна

¹⁶ -хандив, тусламж, бэлэглэл, өвлөх журмаар олж авсан эд хөрөнгө;

¹⁷ -Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна

¹⁸ -Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Орон нутгийн түвшинд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг үндэслэн аймгийн Засаг даргын 2021-2024 оны мөрийн хөтөлбөр, аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөнд уул уурхайн салбарын бодлогыг тусгаж аймгийн Засаг дарга биелэлтийг аймгийн ИТХ-д тайлагнасан байна.
2. Аймагт хэрэгжиж байгаа уул уурхайн томоохон 2 төслийн ТЭЗҮ-ээс эдийн засгийн тооцоолол хийж үзэхэд орон нутгийн орлого өссөнөөр улсын төсвийн ачааллыг бууруулах боломж бүрдэхээр байна.
3. Уул уурхайн томоохон төслийн ашиглалтыг эхлүүлэхээс өмнө Байгаль орчинд нөлөөлөх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор орд ашиглах ТЭЗҮ-д туссан дэд бүтэц болон хөрөнгө оруулалтын ажлуудыг гүйцэтгүүлсэн байх шаардлагатай байна.
4. Төрийн байгууллагууд ААН-ийн гаргасан зөрчилд арга хэмжээ авч байгаа ч эвдэрсэн газрын хэмжээ буурахгүй, зөрчлийг таслан зогсоож чадахгүй байгаа нь цөлжилт нэмэгдэх эрсдэлтэй байна.
5. Ашигт малтмал, газрын тосны газар болон Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын мэдээллийн системийн зөрүүтэй байдлаас шалтгаалан газрын төлбөрийн ногдуулалт үнэн зөв хийгдэхгүй байна
6. Уул уурхайгаас Орон нутгийн төсөвт төвлөрөх орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүй, ногдуулсан татварыг ААН-үүд бүрэн төлөөгүй байна.
7. Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд нь 2022-2023 онд нийт 4,404.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийснийг нийтийн эзэмшлийн зам талбай ногоон байгууламжийн ажилд голлон зарцуулсан нь орон нутгийн хөгжилд хувь нэмрээ өгч байна.
8. Аудитын үр дүнд төсвийн орлого бүрдүүлэлтэй холбоотой 321.8 сая, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 307.4 сая, байгаль орчин, хуулийн хэрэгжилттэй холбоотой 9 зөрчил илэрч байна.

-oOo-

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА Э.ЭНХБАТ ТАНАА:

1. Уул уурхайг түшиглэсэн нэмүү өртөг шингээх, боловсруулах үйлдвэр байгуулах бодлогыг урт дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгах.
2. Уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс орон нутагтай хийсэн гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүр ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж шийдвэр гаргаж байх зайлшгүй шаардлагатай байна.

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:

1. Цаашид аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн төслийн техник эдийн засгийн үндэслэлд тооцоо судалгаа, дүн шинжилгээ хийж орон нутгийн төсвийн орлогод төлөвлөх.
2. Уурхай ашиглах төслийн ТЭЗҮ-ийг авч судалгаа гарган хийгдэхээр төлөвлөсөн дэд бүтэц, хөрөнгө оруулалтын ажлыг хийсний дараа уурхайг ашиглах гэрээ хэлэлцээр хийж, холбогдох зөвшөөрлийг олгох.
3. Эдийн засгийн үр өгөөж багатай, биологийн нөхөн сэргээлтийг хийхгүй байгаа уул уурхай тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй дахин гэрээ байгуулахгүй байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2026 оны 10 дугаар сарын 01-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

-оОо-

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

Газрын төлбөрийн орлого нь Ашигт малтмал, газрын тосны газар болон Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газрын мэдээллийн системийн зөрүүтэй байдлаас шалтгаалан зөрүү ногдож байгаа тул асуудлыг холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлэх саналыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газарт уламжлав.

-oOo-